



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2, 5.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хар хорум пропертийс” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36,195 /гучин зургаан мянга нэг зуун ерэн тав/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,751,262 /арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,787,457 /арван таван сая долоон зуун наян долоон мянга дөрвөн зуун тавин долоо/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-г үүрэг болгож, энэхүү тогтоолын хавсралтад заасны дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Хар хорум пропертийс” ХК /Д.Энхбаатар/-д үүрэг болгосугай:

1/ “Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

2/ Компанийг өөрчлөн байгуулж, нэгдэж байгаа компанийн өмчлөлийн хөрөнгийг “Хар хорум пропертийс” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, шинэчилсэн дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх;


3/ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзлэх хувь
1	“Сүбашид тек” ХХК	11,241,262	71.20%
2	М.Бат-Эрдэнэ	940,000	5.95%
3	Ц.Хүдэрмөнх	940,000	5.95%
4	Г.Дулмаа	940,000	5.95%
5	Т.Дэлгээн	940,000	5.95%
6	Э.Цэндсүрэн	450,000	2.85%
7	Г.Азаяа	150,000	0.95%
8	Ц.Хишигбаатар	150,000	0.95%
9	Бусад 137 хувьцаа эзэмшигч	36,195	0.23%
Нийт дүн		15,787,457	100%

“Хар хорум проптертис” ХК-ийн хувьцааны тоо

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 12-р сарын 28-ны өдрийн
80 дугаар тогтоолын хавсралт

